

Зээлийн эрх нээх гэрээ байгуулах тухай

“Говь” ХК нь “Таван Богд Холдингс” ХХК болон түүний охин компаниудтай хамтран “ХААН” банкттай зээлийн эрх нээх гэрээг шинээр байгуулах асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсгийг удирдлага болгон “Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. “Таван Богд Холдингс” ХХК болон түүний охин компаниуд нь “ХААН” банкттай 83,000,000,000.0 /наян гурван тэрбум/ төгрөгийн дүнтэй, 36 сарын хугацаатай Зээлийн эрх /Олон зориулалттай зээлийн эрх/ нээх гэрээг дараах нөхцөлөөр шинээр байгуулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:

1.1. Зээлийн шугам

1.1.1. Хүү жилийн: Төгрөг 14.4 /арван дөрөв аравны дөрвөн/ хувь, ам.доллар 8.88 /найм зууны наян найман/ хувь,

1.1.2. Хугацаа: 13 /арван гурван/ сар

1.1.3. Валют: төгрөг, ам доллар

1.2. Аккредитив, гадаад, дотоод баталгаа, батлан даалт

1.2.1. Эрсдэлийн шимтгэл /жилийн/: 2.0 /хоёр/ хувь,

1.2.2. Валют: төгрөг, ам.доллар, евро, юань, иен

1.3. Ачилтын өмнөх болон дараах худалдааны зээл

1.3.1. Хүү жилийн: Төгрөг 14.0 /арван дөрвөн/ хувь, ам.доллар SOFR+4 /SOFR+дөрвөн/ хувь, евро EURIBOR+4 / EURIBOR+дөрвөн/ хувь, юань болон иен зээл олгох үед банк тогтоох бөгөөд гаднын банкны эх үүсвэрийн зардал болон банкны маржины нийлбэр дүн

1.3.2. Хугацаа: 6 /зургаан/ сар хүртэл

1.3.3. Валют: төгрөг, ам доллар, евро, юань, иен

1.4. Свop, форвард хэлцэл

1.4.1. Хугацаа: 12 /арван хоёр/ сар хүртэл

1.4.2. Валют: төгрөг, ам доллар, евро, юань, иен

1.5. Гурилын үйлдвэрийн эргэлтийн хөрөнгийн зээл

1.5.1. Хүү жилийн: Төгрөг 18.0 /арван найман/ хувь, хүүгийн хөнгөлөлт 13.0 /арван гурван/ хувь

1.5.2. Хугацаа: 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдрийг дуустал

1.5.3. Валют: төгрөг

20~~23~~²⁴ он ~~11~~¹² сар ~~30~~³¹ өдөр


Дугаар ~~40~~⁴¹


Улаанбаатар хот

2. Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.
3. Зээлийн эрх нээх гэрээ, барьцааны гэрээ, холбогдох бусад гэрээ, бичиг баримтад “Говь” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг “Таван Богд Холдингс” ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирал /Н.Мөнхбат/-д олгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:









Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Д.ХҮРЭЛБААТАР

Б.ЦЭЭНЯМ